



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/89

Номгон

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5а, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Шинээр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах П.Сэндмаа захиралтай “Монос Баянхонгор” ХХК-ний I дүгээр зэрэглэлийн эмийн санд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

2.“Монос Баянхонгор” ХХК-ний эмийн санд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу хуулийн хүрээнд чанартай, хариуцлагатай үйл ажиллагаа явуулахыг үүрэг болгосугай.

3.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан “Монос Баянхонгор” ХХК-ний эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Н.Бямбадорж/-т, Эрүүл мэндийн газар /С.Батцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн салбарын асуудал хариуцсан орлогч /М.Мөнхбат/-д, Нийгмийн бодлогын хэлтэс /Д.Энхжаргал/-т нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Г.БАТЖАРГАЛ

1700094